



АУДИТ  
БАТАЛГААЖУУЛАХ  
ҮЙЛЧИЛГЭЭ

**“БАЯН-АЛДАР ББСБ” ХК-ИЙН  
2019 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭР  
ТАСАЛБАР БОЛГОСОН**

A horizontal green band across the middle of the page contains a faint, dark green silhouette of a city skyline with various buildings and a flag on a pole.

**АУДИТОРЫН  
ТАЙЛАН**

<b>АГУУЛГА</b>		<b>0</b>
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ		1
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН		2
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН		5
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН		6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН		7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		8
ТОДОТГОЛ 1	Байгууллагын талаарх мэдээлэл	9
ТОДОТГОЛ 2	Тайлан бэлтгэсэн үндэслэл	9
ТОДОТГОЛ 3	Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хурааг	10
ТОДОТГОЛ 4	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	13
ТОДОТГОЛ 5	Харилцагчдад олгосон зээл	13
ТОДОТГОЛ 6	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	14
ТОДОТГОЛ 7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	14
ТОДОТГОЛ 8	Үндсэн хөрөнгө	14
ТОДОТГОЛ 9	Биет бус хөрөнгө	14
ТОДОТГОЛ 10	Бусад өр төлбөр	15
ТОДОТГОЛ 11	Дүрмийн сан	15
ТОДОТГОЛ 12	Хүү болон түүнтэй адилтгах орлого	15
ТОДОТГОЛ 13	Хүүгийн бус зардал	16

**2019 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон  
Санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах  
Удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү мэдэгдэл нь “Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн (“Компани” гэх) 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгахад чиглэгдсэн болно.

Удирдлага нь Компанийн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт(СТОУС)-уудын дагуу үнэ зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант хугацааны санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журамд нийцүүлэн үнэн зөв, шударгаар илэрхийлсэн байх ёстой.

**Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага дараах хариуцлагыг хүлээдэг.**

**Үүнд:**

- Компанийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, тууштай мөрдөх
- Ул үндэслэлтэй, хянамгай шийдвэр гаргах болон тооцоолол хийх
- СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг зөрүү буюу өөрчлөлт байгаа бол түүнийг санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- Компани ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаагаа явуулах төсөөлөлд үндэслэж бэлтгэх

**Удирдлага нь мөн түүнчлэн,**

- Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж, ажиллуулах
- Компанийн санхүүгийн байдлыг үнэн зөвөөр, аливаа хугацаанд харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх ажиллагааг зохион байгуулах
- Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэ зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.



Огноо: \_\_\_\_\_

2020-01-28

Ерөнхий Нягтлан Бодогч

**МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг  
16-р хороо, Амарсанаагийн гудамж, 12-1  
Колорадо бизнес төв, 1 давхар, 101 тоот  
Утас: 7013-1044. И-мэйл: info@magicgroup.mn  
Вэб хуудас: www.magicgroup.mn

2020-01-28 дугаар 20-УББ/03/15

танай \_\_\_\_\_-ны дугаар \_\_\_\_\_-т

## АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид “БАЯН-АЛДАР ББСБ” ХК (‘ББСБ’ гэх)-ын 2019 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар ББСБ-ын 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт(‘АОУС’)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёсзүйн олон улсын стандартын зөвлөл(НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёсүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёсзүйн шаардлагын дагуу ББСБ-аас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёсзүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрээр тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

“Баян-Алдар” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2017 оны 10-р сарын 26-ны өдрийн №01 тоот тогтоол, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12-р сарын 14 өдрийн №374 тогтоолын дагуу “Монгоруматрикс гинко ББСБ” ХХК-тай нэгдэж 2019 оны 2-р сарын 20-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлсэн байна.

ББСБ-н нэгтгэлтэй холбоотой анх удаагийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлийн тайланг 2019 оны 1-р сараас бэлтгэсэн байна.

СТОУС 3 “Бизнесийн нэгдэл”-н 61-д “Нэгтгэгч байгууллага нь тухайн хугацааны эсвэл өмнөх тайлангийн хугацаанд гарсан бизнесийн нэгдэлтэй холбоотой тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн залруулгын санхүүгийн нөлөөллийг үнэлэх боломжоор хангахын тулд санхүүгийн тайлангийн мэдээллийг тодруулна” гэж заасан байна.

Хараат бус аудиторын тайлангийн үргэлжлэл...

### **Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага ББСБ-ын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах ББСБ-ын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь ББСБ-ын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

### **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- ББСБ-ын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаатай дотоод хяналтын ойлголтыг олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл болон удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн ББСБ-ын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал ББСБ тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Хараат бус аудиторын тайлангийн үргэлжлэл...

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага (Үргэлжлэл)**

- Тодруулгыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг.

Түүнчлэн бид хараат бус байдалтай холбоотой холбогдох ёсзүйн шаардлагуудыг мөрдсөн гэсэн мэдэгдлийг засаглах удирдлагад гаргадаг бөгөөд бидний хараат бус байдалаа хадгалахад үндэслэл болж болох аливаа бүх харилцаа, бусад асуудлыг, шаардлагатай бол холбогдох хамгаалалтын арга хэмжээний талаар засаг удирдлагатай харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль” -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох “БАЯН-АЛДАР ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



С.Мөнхбаяр  
Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер  
Мэжик Консалтинг Аудит ХХК  
Улаанбаатар хот, Монгол Улс  
2020 оны 01 сарын 23

Үзүүлэлт	Тодотгол	/төгрөгөөр/	
		2018.12.31	2019.12.31
<b>Хүүгийн орлого</b>	12	-	<b>606,889,840.41</b>
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого		-	583,988,860.71
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого		-	12,127,729.65
Харилцах дансны хүүгийн орлого		-	10,773,250.05
<b>Хүүгийн бус орлого</b>		-	<b>19,494,471.03</b>
<b>Хүүгийн бус зардал</b>	13	<b>20,392,100.00</b>	<b>220,224,755.60</b>
<b>ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>(20,392,100.00)</b>	<b>(200,730,284.57)</b>
Зээлийн эрсдэлийн зардал			67,960,016.20
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ</b>		<b>(20,392,100.00)</b>	<b>338,199,539.64</b>
Үндсэн бус үйл ажиллагааны орлого			229,166.76
Үндсэн бус үйл ажиллагааны зардал			12,234,935.00
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал</b>		<b>(20,392,100.00)</b>	<b>326,193,771.40</b>
Орлогын татварын зардал			35,079,719.22
<b>ЦЭВЭР АШИГ</b>		<b>(20,392,100.00)</b>	<b>291,114,052.18</b>

Үзүүлэлт	ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН			/төгрөгөөр/ Нийт дүн
	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Хуримтлагдсан ашиг	
<b>2018 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	<b>20,267,900.00</b>	-	<b>(117,456,008.00)</b>	<b>(97,188,108.00)</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>20,267,900.00</b>	-	<b>(117,456,008.00)</b>	<b>(97,188,108.00)</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг:	-	-	-	-
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-
Хувьцаат капиталын өсөлт	-	-	-	-
<b>2018 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>20,267,900.00</b>	-	<b>(117,456,008.00)</b>	<b>(97,188,108.00)</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>20,267,900.00</b>	-	<b>(117,456,008.00)</b>	<b>(97,188,108.00)</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	96,249,118.13	96,249,118.13
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг:	-	-	291,114,052.18	291,114,052.18
Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-
Хувьцаат капиталын өсөлт	1,972,000,000.00	(3,569,520.00)	-	1,968,430,480.00
<b>2019 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	<b>1,992,267,900.00</b>	<b>(3,569,520.00)</b>	<b>269,907,162.31</b>	<b>2,258,605,542.31</b>

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2018.12.31	2019.12.31
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(90,340.00)</b>	<b>(107,233,636.49)</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>20,000,000.00</b>	<b>3,438,908,533.06</b>
Зээлийн хүүгийн орлого	-	607,791,633.09
Харилцах дансны хүүгийн орлого	-	10,773,250.05
Гадаад валютын арилжааны орлого	-	11,448.58
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	-	19,194,556.50
Хүүгийн орлогын буцаалт	-	-
Бусад үйлчилгээний орлого	20,000,000.00	2,801,137,644.84
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>20,090,340.00</b>	<b>3,546,142,169.55</b>
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	-	-
Үндсэн ба нэмэгдэл цалин	13,676,800.00	87,849,854.47
Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	-	-
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	3,864,000.00	25,667,511.80
Албан томилот, сургалтын зардал	-	12,604,495.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	-	17,152,343.21
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	-	21,249,423.00
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	-	6,603,250.61
Татвар, даатгалын төлсөн мөнгө	973,400.00	107,708,900.41
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	-	7,480,200.00
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	-	1,042,400.00
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	-	21,197,900.00
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	-	3,764,000.00
Ногдол ашгаар олгосон мөнгө	-	336,798,510.25
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	-	2,757,926,300.00
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	1,576,140.00	139,097,080.80
<b>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>112,765,065.00</b>
<b>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>-</b>	<b>125,000,000.00</b>
Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого	-	125,000,000.00
Ногдол ашгийн орлого	-	-
Хандив	-	-
Бусад	-	-
<b>Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>-</b>	<b>12,234,935.00</b>
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	-	11,004,986.00
Торгуулийн зардал	-	-
Бусад	-	1,229,949.00
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(90,340.00)</b>	<b>5,531,428.51</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>439,385.00</b>	<b>349,045.00</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>349,045.00</b>	<b>5,880,473.51</b>

## 1. Байгууллагын талаарх мэдээлэл

"Баян-Алдар ББСБ" ХК нь Монгол Улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооноос Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2018 оны 12-р сарын 14 өдрийн №374 тоот тогтоолоор ББСБ-ын үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 5 ажиллагсадтай байна.

"БАЯН-АЛДАР ББСБ" ХК нь одоогийн байдлаар автомашины, оюутны, визний, бизнесийн, хөрөнгө оруулалтын, хэрэглээний, цалингийн, хашаа байшин барьцаалсан, орон сууц барьцаалсан гэх мэт зээлийн бүтээгдэхүүн харилцагчиддаа санал болгон үйлчилгээ үзүүлж байна.

## 2. Тайлан бэлтгэсэн үндэслэл

### а. Даган мөрдөлтийн мэдэгдэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь НББОУС-н хорооноос гаргаж, мөрдүүлсэн СТОУС-т болон НББОУС-н хорооны Тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэсэн байна.

Түүнчлэн "БАЯН-АЛДАР ББСБ" ХК нь нягтлан бодох бүртгэлээ Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу зохион байгуулсан бөгөөд энэхүү зааврыг Санхүүгийн Зохицуулах Хороо нь СТОУС-тай нийцүүлэн гаргасан байна.

### б. Хэмжилтийн суурь

Зах зээлийн бодит үнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрөөс бусад зүйлсийн хувьд эдгээр санхүүгийн тайлангууд нь түүхэн өртөгт суурилан бэлтгэгддэг.

### с. Үндсэн ба толилуулгын валют

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын төлбөр тооцооны нэгж, ББСБ-ын толилуулгын валют болох төгрөгөөр илэрхийлэгдэн, төгрөгөөр харуулж тайлагнагдсан.

### д. Тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүн зэрэгт нөлөөлөх үнэлгээ, таамаглал ба тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийгдсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

### е. Ирээдүйн үйл ажиллагааны төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь өөдрөг төсөөлөлд суурилан бэлтгэгдсэн.

Өөдрөг төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

### 3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй

#### а. Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнүүдийг гүйлгээ хийгдсэн өдрийн албан ханшаар хөрвүүлдэг.

Түүхэн өртгөөрөө тусгагдсан гадаад валютаарх мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөгт хөрүүлдэг. Хөрвүүлэлтээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүүг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

#### б. Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал

Хүү бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийн хүүний орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүгийн хувийг хэрэглэн орлогын тайланд “Хүү болон түүнтэй адилтгах орлого” ба “Хүү болон түүнтэй адилтгах зардал” гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүгийн орлогоос бусад хүүгийн орлогыг аккред сууриар дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүний орлогыг анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

#### в. Хураамж ба шимтгэлийн орлого

ББСБ-ын хураамж, шимтгэлийн орлого нь ихэвчлэн зээлийн өргөдөл, гүйлгээний болон хугацаа сунгасны шимтгэл зэргээс бүрддэг. Хураамж, шимтгэлийн орлогыг үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь мөнгөн сууриар хүлээн зөвшөөрдөг.

#### г. Хураамж ба шимтгэлийн зардал

ББСБ-ын хураамж, шимтгэлийн зардал нь ихэвчлэн харилцах дансны шимтгэл, санхүүгийн хураамж зэргээс бүрддэг. Хураамж, шимтгэлийн зардлыг үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь мөнгөн сууриар хүлээн зөвшөөрдөг.

#### д. Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. ББСБ-ын татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татварын хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

#### е. Үйл ажиллагааны түрээсийн төлбөр

Түрээсийн зардлыг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

#### ж. Ажиллагсдын тэтгэвэр, тэтгэмжийн төлөвлөгөө

Ажиллагсдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн даатгалын байгууллагад төлж буй нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрийг агуулдаг. Энэхүү тодорхойлсон тэтгэмжийн ажил олгогчийн ажилтнахаа өмнөөс төлөх дүнг гарсан үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрдөг.

#### з. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгө нь гар дээрх бэлэн мөнгө, арилжааны банкин дахь харилцах данснаас бүрдэж байна.

#### и. Зээл ба урьдчилгаа

Тус ББСБ-ын харилцагчдад олгосон зээл нь зээл ба авлагаар ангилагдсан. Эргэн төлөгдөхөөр тооцоолсон дүнг тусгах зорилгоор зээлийн эрсдлийн санг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

- j. Өмч, Барилга, Тоног төхөөрөмж
- i. Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөмжийг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Өмч, барилга, тоног төхөөмжийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрдэнэ.

Үл хөдлөх хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа үеэс дахин үнэлсэн үнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь бүртгэнэ.

Үл хөдлөх хөрөнгөөс бусад үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

Өмч, барилга, тоног төхөөмжийг борлуулснаас үүссэн олз гарзыг борлуулж буй үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэтэй харьцуулж тодорхойлдог бөгөөд цэвэр дүнгээр орлогын тайланд "бусад олз/гарз" -аар хүлээн зөвшөөрдөг.

Хэрэв дахин үнэлсэн үндсэн хөрөнгийг борлуулах тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдэл санд байгаа дүнг хуримтлагдсан ашиг руу шилжүүлдэг.

- i. Дараа үеийн зардал

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна.

Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

- ii. Элэгдэл

Элэгдлийг үндсэн хөрөнгийн тогтоосон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар байгуулж, орлогын тайланд зардлаар харуулдаг. Тогтоосон ашиглалтын хугацаа нь дараах байдалтай байна.

Барилга	40 жил
Тавилга	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер	3 жил

- i. Үнийн бууралт

Үнийн бууралт үүссэн тухай биет нотолгоо байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор ББСБ-ын хөрөнгийн дансны үнийг балансын өдөр бүр шалгадаг. Ийм шинж тэмдэг байгаа бол тухайн хөрөнгийн эргэн нөхөгдөх боломжит дүнг тооцдог.

- i. Зээлийн үнийн бууралт

Зээл нь эргэн төлөгдөхөд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах тусгай болон ерөнхий нөөцийг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн. Зээлийн үлдэгдлийг шалгасны үндсэн дээр түүний үнэ нь бодиттойгоор буурч байгаа нь тодорхойлогдсон зээлийн дансны үнийг эргэн нөхөгдөх боломжтой

дүн хүртэл нь бууруулж, тусгай нөөцийг байгуулдаг. Ижил төрлийн багцын дансны үнийг эргэн нөхөгдөх боломжтой дүн хүртэл нь бууруулж, тусгай нөөцийг байгуулдаг. Ижил төрлийн багцын дансны үнийг балансын өдрөөрх тооцоолсон эргэн нөхөгдөх боломжтой дүн хүртэл нь бууруулж ерөнхий нөөцийг байгуулдаг. Нөөцийн өсөлтийг орлогын дэлгэрэнгүй тайланд хүлээн зөвшөөрдөг. Эрсдлийн нөөцийг байгуулахдаа Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан журмыг баримталдаг. Зээл эргэн төлөгдөхгүй нь тодорхой болмогц бүх шаардлагатай эрх зүйн горимуудыг хийж гүйцэтгэсний дараа алдагдлыг тооцож, зээлийг болзошгүй эрсдэлээс хамгаалах сангаас хаадаг. Балансын өдрөөс хойш үнийн бууралтын алдагдлын дүн багасвал, бууруулж бүртгэсний дараа тохиолдсон үйл явдалтай холбогдож бууруулсан бичилт буюу нөөцийг орлогын тайлангаар дамжуулан буцаан бүртгэдэг.

ii. Өмчлөх бусад хөрөнгийн үнийн бууралт

Төлөгдөх хугацаа нь хэтэрсэн зээлийн үндсэн өр ба хүүгийн төлбөрийг барагдуулах зорилгоор компанийн эзэмшилд бүрэн шилжүүлэн авсан, борлуулах зориулалтай хөрөнгийг өмчлөх бусад хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрдөг. Өмчлөх бусад хөрөнгийг өмчлөлд авснаас хойш Монгол банкны ерөнхийлөгч ба Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан журмын дагуу борлогдоогүй хугацаа болон чанарт нь суурилан эрсдлийн нөөцийг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

iii. Бусад хөрөнгийн үнийн бууралт

Мөнгөний орох урсгал бий болгодоггүй хөрөнгүүдийн хувьд эргэн нөхөгдөх дүнг тухайн хөрөнгийн харьяалагдаж буй мөнгө бий болгогч нэгжийнх нь хувьд тодорхойлдог. Хөрөнгийн эсвэл мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх үнээсээ давсан үед үнийн бууралтын алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Эргэн нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орсон бол үнийн бууралтын алдагдлыг буцаан бүртгэдэг. Үнийн бууралтын бүх буцаалтыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

b. Нөөцүүд

ББСБ нь өмнөх үеийн үйл явдлын үр дүнд хууль ёсны хариуцлага хүлээж буй болон эдийн засгийн үр өгөөжийн гарах урсгалд хариуцлагаа биелүүлэх шаардлагатай болсон үед балансад нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

- Зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлээс хамгаалах нөөц болон өмчлөх бусад хөрөнгийн борлогдохгүй байх эрсдлийн түвшин нь он тус бүрийн хувьд дараах байдалтай байсан.

Үзүүлэлт	2018 он	2019 он
Хэвийн	0%	0%
Хугацаа хэтэрсэн	5%	5%
Хэвийн бус	25%	25%
Эргэлзээтэй	50%	50%
Муу	100%	100%

Монгол Банкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2014 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн А-136/184 тоот хамтарсан тушаалаар хэвийн зээлийн нөөц 1 хувь байсан байна.

Монгол Банкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 244/125 тоот хамтарсан тушаалаар хэвийн зээлийн нөөцийг 0 хувь болгон өөрчилсөн байна. Энэ журмыг 2015 оны 07 сарын 01 нээс эхлэн мөрдсөн байна.

Зээл, өмчлөх бусад хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд, түүний эргэн төлөгдөх магадлалын талаарх удирдлагын үнэлгээнд суурилан зөвхөн тусгай нөөцүүдийг байгуулдаг.

#### 4 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Касс дахь бэлэн мөнгө	330,547.00	967,209.90
Банкин дахь мөнгөн хөрөнгө	18,498.00	4,913,263.61
	<b>349,045.00</b>	<b>5,880,473.51</b>

2019-12-31-ны өдрийн байдлаар мөнгөн хөрөнгийн 16 хувийг касс дахь мөнгөн хөрөнгө, 84 хувийг банкинд байгаа мөнгөн хөрөнгө эзэлж байна. Мөн нийт хөрөнгийн 0.26 хувийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө эзэлж байна.

"Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.

#### 5 Харилцагчдад олгосон зээл

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Харилцагчдад олгосон зээл	-	2,267,553,647.14
Нийт зээл /цэврээр/	-	2,160,591,494.64
	<b>-</b>	<b>106,962,152.50</b>

#### Зээлийн ангилал

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Хэвийн зээл	-	1,987,260,385.63
Хугацаа хэтэрсэн зээл	-	64,737,911.96
Хэвийн бус зээл	-	26,006,590.55
Эргэлзээтэй зээл	-	189,548,759.00
	<b>-</b>	<b>2,267,553,647.14</b>

2019-12-31-ны байдлаар 87.64 хувийг хэвийн зээл, 2.85 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 1.15 хувийг хэвийн бус зээл, 8.36 хувийг эргэлзээтэй зээл эзэлж байна. Нийт хөрөнгийн 77.01 хувийг эзэлж байна.

2019-12-31-ны өдрийн байдлаар зээлийн насжилт нь доорх байдалтай байна. /мян.төг/

хугацаа	1-3 сар	3-6 сар	6-12 сар	1-3 жил	3-5 жил	нийт
зээл	63,111.1	592,789.9	966,663.3	579,330.1	65,659.3	2,267,553.7
Зээлийн ангилал						
Хувийн сектор						537,882,275.39
Иргэд						1,729,671,371.75
						<b>2,267,553,647.14</b>

2019-12-31-ны өдрийн байдлаар нийт зээлийн 76.28 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байгаа бөгөөд Банк Бус Санхүүгийн Үйл Ажиллагааны Тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-д "Банк бус санхүүгийн байгууллагаас нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрч болохгүй" гэж заасныг зөрчөөгүй байна.

2019-12-31-ны өдрийн байдлаар 89.27 хувийг хэвийн зээл, 2.88 хувийг хэвийн бус зээл, 7.85 хувийг эргэлзээтэй зээл эзэлж байна. Нийт хөрөнгийн 77.01 хувийг эзэлж байна.

"Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.

## 6 Хуримтлуулж тооцсон хүүний орлого

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	86,133,630.27
	<b>-</b>	<b>86,133,630.27</b>

Компани гэрээний хүүгийн авлагыг хуримтлуулж тооцоолон бүртгэж байна.  
 "Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.

## 7 Урьдчилж төлсөн зардал, тооцоо, Дараа тайлан

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	4,884.00	1,971,751.00
Дараа тайлангийн тооцоо	-	575,800.00
	<b>4,884.00</b>	<b>2,547,551.00</b>

Шүүхийн шийдвэрт тэмдэгтийн хураамж төлсөн төлбөрийг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн байна.

"Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.

## 8 Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Барилга байгууламж	-	-
Хуримтлагдсан элэгдэл /барилга байгууламж/	-	-
Эд хогшил	-	6,297,600.00
Хуримтлагдсан элэгдэл /эд хогшил/	-	(1,082,423.96)
Техник хэрэгсэл	3,009,807.00	17,858,607.00
Хуримтлагдсан элэгдэл /эд хогшил/	-	(8,072,087.95)
	<b>3,009,807.00</b>	<b>15,001,695.09</b>

УБГ:У-2203001235 дугаартай барилга байгууламжийг зарж борлуулсан.

Үндсэн хөрөнгө нь Нийт хөрөнгийн 0.66 хувийг эзлэж байна.

"Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.

## 9 Биет бус хөрөнгө

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Биет бус хөрөнгө	-	714,999.89
	<b>-</b>	<b>714,999.89</b>

Интерактив Би Ай ХХК-ний Спинел 6.0 програм хангамжийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна.

"Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.

## 10 Бусад өр төлбөр

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
ХХОАТ-ын өглөг	301,844.00	2,638,450.75
Орлогын албан татварын өглөг	-	9,625,851.34
Бусад	100,250,000.00	
	<b>100,551,844.00</b>	<b>12,264,302.09</b>

2019-12-31-ны байдлаар бусад өр төлбөрийн 25 хувийг татварын өр төлбөр эзэлж байна.  
"Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.

## 11 Дүрмийн сан

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Дүрмийн сан	20,267,900.00	1,992,267,900.00
Хувьцаа /ширхэг/	202,679.00	19,922,679.00

2017 оны 10 сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигдийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу  
"Монгорүматрикс гинко ББСБ" ХХК нэгтгэн 1,992,267,900.00 төгрөгийн хувьцаат капитал нь  
нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 20,470,579.00 ширхэг хувьцаанаас бүрдэж байна.

"Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.

## 12 Хүү болон түүнтэй адилтгах орлого

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Зээлийн хүүний орлого	-	596,116,590.36
Харилцах дансны хүүний орлого	-	10,773,250.05
	-	<b>606,889,840.41</b>

"Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.

### 13 Хүүгийн бус зардал

Үзүүлэлт	2018.12.31	2019.12.31
Үндсэн болон нэмэгдэл цалин	18,816,000.00	108,021,070.00
Нийгмийн даатгалын зардал	-	13,373,861.13
Албан томилолт	-	9,921,495.00
Сургалтын зардал	-	2,683,000.00
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай	-	1,042,400.00
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	-	21,177,900.00
Түрээс	-	16,884,000.00
Ашиглалтын зардал	-	268,343.21
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-	6,508,246.70
Харуул хамгаалалтын зардал	-	1,258,140.00
Харилцаа холбоо, интернет	-	2,280,190.00
Шатахуун болон тээврийн зардал	-	18,572,533.00
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	-	396,700.00
Зохицуулалтын хураамжийн зардал	-	3,764,000.00
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	-	767,800.00
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	340,000.00	8,041,200.00
Бичиг хэргийн зардал	-	818,480.00
Ариун цэврийн зардал	-	333,740.00
Үл хөдлөх хөрөнгийн татвар	-	662,500.00
Харилцагчдын сургалт судалгааны зардал	-	2,199,630.37
Бусад	1,236,100.00	1,249,526.19
	<b>20,392,100.00</b>	<b>220,224,755.60</b>

Компани нь өдөр тутмын үйл ажиллагаа явуулахын тулд хүүгийн бус зардлуудыг гаргадаг байна.

2019-12-31-ны байдлаар хүүгийн бус зардлын 49.05 хувийг цалингийн зардал эзэлж байна. "Баян-Алдар ББСБ" ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайланг анх удаа бэлтгэж байна.